

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ИЛТГЭХ ХУУДАС

“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас баталсан
тогтоол шийдвэрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ хийсэн тухай”

2025 оны 06 сарын 12 өдөр

Улаанбаатар хот

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2021 онд батлагдсан 1 тогтоол, 2022 онд батлагдсан 1 тогтоол, 2024 онд батлагдсан 1 тогтоол, 2025 онд батлагдсан 11 тогтоолын нийт 14 заалтыг хяналтад авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж ажиллалаа.

Хяналт-шинжилгээний зорилго нь дээд газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт нь үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, явцын үнэлгээ хийж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

Хяналт-шинжилгээний ажлыг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” –ыг үндэслэл болгон гүйцэтгэсэн.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 14 тогтоолын 14 заалтаас

- Хэрэгжсэн -3
- Хэрэгжээгүй -1
- Хугацаа болоогүй -10 заалт байна.

Хяналтад авсан заалтын хэрэгжилтийн хүснэгт

Д/д	Тогтоол шийдвэрийн нэр	Хяналтад авсан заалтын тоо	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй
1	Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны тогтоол	14	3	1	10

Дүгнэлт :

Хяналтад авагдсан 14 тогтоолын 14 заалтын хэрэгжилт 75 хувьтай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.7-д Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дараах аргачлалаар дүгнэнэ”.

3.7.1.“хэрэгжсэн”-үүрэг, даалгаврын хэрэгжилт бүрэн хангагдсан (зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, төсөв санхүүгийн асуудлыг шийдэж, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, удирдах дээд байгууллагад өргөн барьсан гэх мэт төлөвлөсөн үр дүн гарсан);

3.7.2."хэрэгжээгүй"-(шийдвэрийн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил, боловсруулалтын шатанд байгаа, төсөв шийдэгдсэн боловч хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй);

3.7.3."хугацаа болоогүй"-(шийдвэрт тусгайлан заасан хугацаа болоогүй, эсхүл өөрөөс хамаарах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бусад[1] хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжилт хангагдаагүй, мөн урт хугацаанд хэрэгжүүлэх шаардлагатай бол -(ХБ)) гэж заасны дагуу дүгнэсэн.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахаар үүрэгжүүлсэн байгууллагуудад дараах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Үүнд:

1. Хэрэгжилт нь удаашралтай байгаа зорилт, арга хэмжээний биелэлтийг ахиулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах;

2. Хэлтэс, тасгууд өөрийн ажлын үнэлгээг хагас жил тутам хийж хяналт-шинжилгээний дүнгийн мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах;

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргахдаа зорилт, арга хэмжээ болон тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг үнэлэн, үр дүн, үр нөлөөг тодорхой тусгах, хэрэгжилтийг хугацаанд нь чанартай хүргүүлж байх.


4. Тухайн жилд шаардагдах төсвийн хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, биелэлтэд төсвийн зарцуулалтыг хамтад нь тайлагнана.

5. Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын 3.9-д Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй, холбогдох нотлох баримтыг хавсаргаагүй, цаглабарт заасан хугацаанд хэрэгжилтийг нэгдсэн системд тайлагнаагүй, 2 буюу түүнээс олон удаа товлосон хугацаанд тайлагнаагүй, 2 жил дараалан үүрэг даалгавар биелэгдээгүй бол ерөнхий дүнгээс 5-10 оноо хасаж тооцно гэж заасан байх тул нотлох баримтыг хавсаргаж ирүүлэх

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН

ДАРГА



С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

МЭРГЭЖИЛТЭН



О.ЯНЖИНЛХАМ